

ӨРТГИЙН ОНОЛЫГ ДАХИН ШИНЭЧЛЭХҮЙ

(XXI зууны сэтгэлгээ)

Ч.Баянжаргал

Энэ асуудал юугаараа онцлог, шинэлэг вэ?

- Монголчууд өнөөдөр, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих явцад олон зууны чанадаас үүдэлтэй өрнөдтийн янз бүрийн онол номлолыг нутагшуулах аргаар хэрэглэж буйг тунгааж,
- Тэдгээр онол сургаалуудыг урсгалаар шүтэн дагаж, ердийн хуулбарлах, даган давтах тогтонги сэтгэлгээний муу зуршил хавтгайрсанд шүүмжлэлтэй хандаж,
- Бусдын оюуны бүтээлд дагаар орсон дуурайх сэтгэлгээг эвдэн, асуудлыг бодитойгоор үзэж, баримт нотолгоо бүхий

1. Асуудлыг тавихын учир

Өдгөө, өртгийн онолын асуудлыг хуучин, шинэ сонгодог сургуулиудаар дамжин нэгмөр шийдэгдсэн гэж үзэх явдал зонхилж байна. Гэвч, сүүлчийнх буюу эдийн засгийн шинэ сонгодог онолын гол тулгуур болсон Австрийн сургууль (маржинал үзэл)-ийн томъёолол ч, түүний англи төлөөлөгч Альфред Маршаллын нотолгоо ч бодит байдалтай дүйхгүй болсон нь асуудлыг шинээр үзэхийн учир шалтгаан болов.

Өртөг бол: үйлдвэрлэлийн орцууд бүхэлдээ хөдөлмөрийн зардал болон нэгтгэгдсэний дүн мөн гэдэг ойлголт хэвээр хадгалагдах ёстой болох нь өнөөдөр улам бүр тодорч байна. Эдийн засаг юуны өмнө, хүмүүний анхдагч хэрэглээ буюу амьд явах эрхийн үндэс болох материаллаг баялгийг үйлдвэрлэн бүтээх явдал мөн. Энэхүү үйлдвэрлэн бүтээх үйл явцад газар, капитал, хөдөлмөр нэгдэн оролцдог атал эцсийн дүнг зөвхөн хөдөлмөрөөр нэгтгэн тооцох нь зөв үү? Үүнийг зөв хэмээн нотлохын тулд газар, капитал хоёрын талаар бяцхан тодруулж тэмдэглэе.

1. Газар: Энэ бол ердийн ухамсарын түвшинд олон нийтийн ойлгодгоос огт өөрөөр онолын түвшинд буудаг, ихээхэн өргөн хүрээтэй ойлголт. Газар бол хүний хөдөлмөрийн үр дүн биш гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ газар үгүй бол хөдөлмөр үгүйн адил, хөдөлмөргүйгээр газрын баялаг хүмүүнд хүртэхгүй нь бас тодорхой.

Сонгодогууд юу гэснийг үзье. Ульям Петти: “Хөдөлмөр бол баялгийн эцэг бөгөөд идэвхтэй зарчим, харин газар түүний эх юм” /1.54/ хэмээн бичсэн. Үүнийг Карл Маркс бүрэн хүлээн зөвшөөрч “Капитал”-ынхаа I ботид эшлэн өгүүлсэн байдаг. Түүнчлэн шинэ сонгодог онолын нэг том төлөөлөгч, Австрийн Людвиг фон Мизес: Хүний хөдөлмөр аяндаа аж амьдралыг сайн сайхан болгож чадахгүй. Хөдөлмөрийг үр бүтээлтэй болгохын тулд байгалиас бидний мэдэлд өгсөн материаллаг нөөц дээр хөдөлмөрлөх хэрэгтэй (5.21) гэсэн байна. Эдгээрээс үзэхэд аль ч үеийн сонгодогууд газрыг анхдагч утгатайгаар хөдөлмөртэй шууд холбон үзжээ. Ийнхүү газрын эдийн засгийн утга агуулгыг хөдөлмөрөөс ангид авч үзэх ямарч үндэсгүй юм. Хүн үгүйгээр ертөнцийн амьдралыг төсөөлж болохгүйн адил газрын асуудлыг хүн - хөдөлмөрөөс салангид үзэж, түүний эдийн засгийн утга агуулгыг тодорхойлох, үнэлэх, ойлгох аргагүй билээ. Үүнээс өөрөөр үзэхэд хүрвэл тэр нь, газар хүн хоёрын “үйлийн эрхээр” холбогдсон холбоосыг зүгээр мал, амьтны сүрэг газар дээр бэлчихтэй адилаар үзсэн явдал болно.

Людвиг Мизесийн бичсэнийг үргэлжлүүлэн авч үзвэл: Дэлхийн бодис хүчин хийгээд хүний хөдөлмөр бол үйлдвэрлэлийн хоёр хүчин зүйл бөгөөд энэ хоёр хүчин зүйл хоорондоо зорилго чиглэлтэй харилцан үйлчилсний дүнд бидний материаллаг хэрэгцээгээ хангадаг бүх бараа таваар бий болдог юм. Үйлдвэрлэхийн тулд хөдөлмөрлөхөөс гадна олонхи нь газрын хөрсөнд байдаг байгалийн түүхий эд, нөөц ресурс төдийгүй үйлдвэрлэлд хэрэгтэй байгалийн эдгээр анхдагч хүчин зүйлүүдийг ашиглан урьд өмнө хөдөлмөр зарцуулж хийсэн завсарын бүтээгдэхүүнийг оролцуулан үйлдвэрлэлийн материаллаг хүчин зүйлсийг ашиглах хэрэгтэй. Үүний дагуу эдийн засгийн хэлээр хөдөлмөр, газар дэлхий, капитал гэж үйлдвэрлэлийн гурван хүчин зүйлсийг ялгаж үздэг юм гээд газар дэлхий гэж байгаль эхээс бидний мэдэлд өгсөн хөрсөн дээр, дор, ус, агаарт байгаа бодис хүчийг хэлж байгаа юм” (5.21-22) хэмээн тов тодорхой бичсэн байна.

Түүнчлэн А.Маршалл: үйлдвэрлэлийн хүчин зүйл гэдэгт олонхигоо газар, хөдөлмөр, капитал гурвыг оруулдаг бөгөөд ашигтай тал нь хүний хөдөлмөрөөр бий болсон материаллаг зүйлс капиталд хамаарч, хөдөлмөрийн үр дүнгээр бүтээгүй зүйлс нь газарт хамаарна. “Газар” гэдэг нэр томъёо асар өргөн утгатай болсоноос түүнд газар шороо, далай, гол мөрөн, нарны гэрэл, бороо, салхи, хүрхрээ зэрэг дээрх ашигт зүйлсийн байнгын эх булгууд бүгд хамаарагддаг болжээ. (3.113) гэсэн байна. Бидний хувьд, дэлхийн гадаргуу, түүний хөрс, ой, ургамал бүхий орон зайн давхаргыг газар хэмээн үзнэ. Энэ

бүхнийг хөдөлмөргүйгээр үйлдвэрлэл, эдийн засгийн эргэлтэд оруулах арга байхгүй. Ингэхээр газар хэмээх ганц үгээр илэрхийлэгдэж байгаа тэр бүх нөөцийг хөдөлмөрийн адил утгаар эдийн засгийн тооцоололд оруулах нь зүйн доторхи хэрэг ээ.

2. *Капитал, капиталын нөөц* ресурс гэдэг нь газар дэлхийн юмнаас хөдөлмөрөөр үйлдвэрлэсэн, цаашдын үйлдвэрлэлд хөдөлмөрийн зүйл (үйлдвэрлэлийн хэрэгслэл – Ч.Б) болдог бүх төрлийн машин, багаж зэвсэг, хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэргийг хэлж байгаа хэрэг гэж мөнөөх Л.Мизес бичсэн бий. Энд К.Марксын томъёоллыг ашиглавал, үйлдвэрлэлийн эдгээр материаллаг хүчин зүйлүүд бол биежсэн хөдөлмөр мөн. Ийнхүү үйлдвэрлэлийн бүх зардал эцсийн дүнд гагцхүү хөдөлмөрийн зардал бөгөөд өртгийн нэгдмэл үндэс болдог. Хөдөлмөрийн нийт зардлыг мөнгөөр тооцож нэгтгэн дүгнэх ёстой. Энэ нь өртгийн хэмжээ болно. Мөнгө, угаас өртгийн хэмжүүрийн үүрэг гүйцэтгэдгийг дэлхий даяараа мэднэ. Өртгийн мөнгөн илэрхийлэлийг үнэ хэмээдэг нь бас эдийн засгийн онолын үндсэн томъёолол. Энэ талаар ямар нэг маргаан үгүй билээ. Харин тухайн үнийг, тухайн үеийн зах зээл хүлээн авах, эсэх нь өөр асуудал.

2. Маржинал онолын мөн чанар

Хүн төрөлхтний хөгжлийн өнөөгийн тэргүүний хэсгийн хүрсэн түвшинг үйлдвэржсэний дараах нийгэм, мэдээллийн хөгжилд үндэслэсэн нийгэм, харилцаа мэдээллийн технологийн хөгжлийн үе гэх мэтээр нэрлэж буй нь нэг талаас зөв боловч, нөгөө талаас, өнгөц, хэтэрхий сэтгэл хөөрлийн шинж бүхий үлэмж субъектив дүгнэлт. Орчин үеийн нийгмийн шинж чанарын тухай онолын ийм томъёололд материаллаг үйлдвэрлэлийн шийдвэрлэх ач холбогдлын тухай үзэл санаа баттай хадгалагдаж байх учиртай. Үүнд өртгийн онол хамаарна.

Өнөөдрийн материаллаг үйлдвэрлэлийн тулгуур хүч нь цул хар төмрөөс бүрдсэн, уур утаа савссан нүсэр механик машин, булчинлаг бадриун ажилчны тухай төсөөллөөс ангид билээ. Гэлээ ч хүн, машин (капитал) хоёр л бүхнийг хөдөлгөж байгаа нь үнэн шүү дээ. Эдгээр нь үйлдвэрлэхүй хүчний мөнхийн үндсэн элементүүд.

Хүн төрөлхтний түүхэнд анх удаа, амьдралын тулгуур үндэс - материаллаг зүйлсийг байгальд байгаагаас нь хавьгүй ихээр, илүү баялаг агуулгатайгаар бүтээн бий болгогч хүмүүсийн хамтын үйл ажиллагаа болох үйлдвэрлэлийн хүрээнд судалгаа шинжилгээний ажлыг чиглүүлж бас, шинжлэх ухааны цоо шинэ аргыг нээн олж хэрэглээд, таваар хэмээх эд баялгийн эдийн засгийн агуулга, мөнгөний мөн чанар зэргийг танин мэдэх болсоноор энэ шинжлэх ухаан сонгодог шинжийг олсон билээ.

Шинэ сонгодог онол бүр эхнээсээ туйлшралд автжээ. XIX зууны 70-аад онд үүссэн ахиуцын (маржинал) хувьсгалын дүнд аливаа таваарын өртөг хөдөлмөрөөр бус, гагцхүү хэрэглэгчийн сонирхол таашаал буюу тэдний хүсэл зоригт тулгуурласан субъектив үнэлэмжээс хамаарна гэх болсон байна. Энэ өрөөсгөл ойлголт эдийн засгийн онолд удтал ноёрхож байгаа бөгөөд өдгөө монголд нэгэнт “импортын бүтээгдэхүүн” болж дуураймлаар хэрэглэгдэж байна. Урьд өмнө ягшмалаар /догматик/ хэрэглэж байсан ангичлах онолыг чухам тэр агуулгаас нь (ангийн) чөлөөлж шинжлэх ухааны хувьд түүний үнэтэй санааг улс төр, үзэл суртлаас ангид авч үзэх явдал чөлөөт сэтгэлгээ, оюун санааны болон нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудал болон тавигдсан. Гэвч хүүхдээ, түүнийг угаасан хиртэй устай нь цуг цацчихаж болохгүйсэн. Өөрөөр хэлбэл, өмнөх сонгодог онолын тулгын нэгэн чулууг өнөөгийн маягаар улс төржүүлж, үзэл сурталжуулан, өмнөх үеийн улс төр, үзэл суртлын угаадастай цуг цацчихаж болохгүй.

“Шинэ сонгодог сургаалаар бол солилцоонд зориулагдсан эдийн засгийн эд баялгийг таваар гэнэ” гээд таваар бол хөдөлмөрийн үр дүн байх ёстой гэдэг ойлголттой энэ тодорхойлолт эрс зөрүүтэй байгааг ажиглахгүй өнгөрч болохгүй” хэмээн манай нэг томоохон эдийн засагч захижээ. (4.47) Энэ бол эндүү ташаа захиас юм.

Аливаа баялаг зөвхөн хөдөлмөрийн үр дүнд л хүний хэрэгцээнд нийцэмжтэй болж, солилцоонд зориулагддаг бусуу. Солилцоонд зориулагдсан эд баялаг буюу таваар бол хөдөлмөрийн л үр дүн болохоос өөр юу ч биш, таваар бол сайхан сэтгэлийн болон хүсэл мөрөөдлийн амттай зүүдний үр бүтээл биш.

Манай зохиогч бас: “Эд юмс ашигт чанар, онцлог шинжээрээ хүний аль нэгэн хэрэгцээг хангахуйц байвал тэр нь уг юмсыг хэрэгцээний өртөгтэй болгоно. Талын мөөг, ойн жимс, ан амьтан хэн нэгний үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүн биш боловч хэрэгцээний өртөгтэй” /4.48/ гэсэн буй. Тиймээ ээ! *хэрэгцээний өртөг* гэдэг бол ашигтай шинж чанар бүхий эд баялаг мөн. Энд жишээ болгосон зүйлсийн хэрэгцээний өртөг байгальд бий болжээ. Харин тэдгээрийг хүн л хөдөлмөрөөрөө арилжааны өртөгтэй буюу солилцоонд оруулах боломжтой болгодог. Ийнхүү тэдгээр баялаг хэрэгцээний өртөг, өртгийн нэгдэл болж таваарын шинж нь бүрдэж байгаа юм.

Үйлдвэрлэгч, үйлчлэгч хаана ч байлаа гэсэн, юу хийдэг ч байлаа гэсэн огт ялгалгүйгээр биеийн болон оюуны эрчим хүч зарцуулдаг. Үүнийг амьд буюу хийсвэр хөдөлмөр гэдэг. Энэхүү хөдөлмөрийн дүнд л таваарыг ижил утгад оруулан зэрэгцүүлж үзэх, үнэлэх боломж бүрдэнэ. Энэ бол арилжааны өртгийн үндэс. Арилжааны өртөг гэдэг бол ерөөс, өртөг гэж нэрлэж байгаа тэр л зүйл буюу, тавааруудын өртгийн тоон харьцаа. Өөр өөр эд юмсыг тэдгээрт шингэж орсон нэг ерөнхий үндэс болох хөдөлмөр зарцуулалтад нь тулгуурлан зохих тоон харьцаагаар хооронд нь дүйлгэн солилцох нөхцөл бүрдэнэ. Үүнд л хамаг учир бий билээ. Энэ бол хөдөлмөр - өртөг гэсэн нэг л юм.

Өртөг, үнэ хоёр амин холбоотой боловч нэг юм биш. Өртөг бол үнийн үндэс. Үнэ нь өртгийн хэмжээг зарлан мэдээлэгч. Өртөг бол бодит зардалд үндэслэсэн объектив байдал. Тэгвэл үнэ зах зээлийн ханамж (эрэлт)-аас хамааран өртгийн хэмжээнээс дээш, доош хэлбэлздэг буюу өртгийг тойрон эргэлдэж байдаг субъектив шинж бүхий үзэгдэл болно. Чухам энэ л өртөг, үнэ хоёрын хооронд зөрчил үүсэхэд хүргэж байгаа юм. Энэ субъектив хүчин зүйлийг эдийн засгийн шинэ сонгодог онол хэрэглэгчийн таашаал буюу сэтгэл ханамж хэмээнэ.

Үнийн хэлбэлзэл өртгийг хөндөхгүй. Өртгийн хэмжээ тооцогдоод тогтоохдог объектив зүйл. Харин үнийн хэлбэлзэл нь нийлүүлэгч (үйлдвэрлэгч) ашиг олох уу? алдагдалд орох уу? эсвэл эдгээр нь тэг (0) –тэй тэнцэх үү? гэдгийн аль нэгэнд л хүргэнэ. Тийм байх атал үнийн савалгааг өртгийн савалгаа мэтээр төсөөлж, тэр тутмаа өртөг хэрэглэгчийн хүсэл таашаалаас хамаардаг мэт үзэх нь үнэнхүү таашаарал мөн. Тийм гэнэн ойлголтын улмаас өртгийн талаархи урьдын сонгодог онолын төгс гүйцсэн, мадаггүй томъёоллыг сөргөж, түүнийг элдвээр баалах болсон байна.

Маржинал хувьсгалын дүнд бий болсон томъёолол буюу өртгийн тодорхойлогч хүчин зүйл бол хэрэглэгчийн хүсэл таашаал гэх нь бодит байдалд ч, онолын сэтгэлгээнд ч хүлээн зөвшөөрөгдөх зүйл биш.

Шинэ сонгодог онолынхон таваарын өртөг, үнэ хоёрыг ялган зааглаж чадаагүй, тэдгээрийг нэг юм мэт үзэх субъектив үзэл баримтлалынхаа улмаас тийм хуумгай дүгнэлтэд хүрсэн нь тодорхой ажээ.

Аливаа таваар цаг үеийнхээ ур, ухааны (хөдөлмөрийн) үр шим болж байдаг учраас түүний үнэт чанар буюу хэрэгцээний өртгийн агуулга байнга баяжиж, хэрэглэгчийн таашаалыг өдөөж, тэр хэрээр үнийн түвшинд нөлөөлдөг.

Үнэ бол өртгийг борлуулах хэлбэрийн хувьд, тухайн таваарын олдоц, хэрэглэгчийн таашаал сонирхолтой холбоотойгоор хэлбэлзэж байдаг. Үүний улмаас таваар зах зээл дээр заавал өртгөөрөө (өртөгтэй тэнцүү үнээр) худалдагдах албагүй. Харин хөдөлмөрийн дундаж зардалтай тэнцэх “үйлдвэрлэлийн үнэ”-ээр худалдагдахад хүрдэг хэмээн сонгодогууд судлан тогтоосон билээ. “Хөдөлмөрийн дундаж зардал”, “Үйлдвэрлэлийн үнэ” гэдгийн талаар жич тодруулан ярилцаж болно.

3. Австричууд ба монголчууд

Энд авч үзэж буй асуудлын талаар австричууд юу хийсэн бэ? Тэр нь дэлхий дахины эдийн засгийн онолын сэтгэлгээнд ямар байр суурьтай байна вэ? Манайхан уг асуудлыг хэр зэрэг бодож тунгааж байна вэ? Зохиолоос нь энд эшлэн авч буй манай зохиогч гэхэд л өртөг, үнэ, ашигт чанар гэсэн

ойлголтуудыг өмнө, хойно нь оруулан, адилхан ч юм шиг, адилгүй ч юм шиг болгон хольж сүлэлдүүлэн бичсэн байна.

Аливаа баялгийн ашигт чанарын тухай асуудал бол таваарын хэрэгцээний өртгийн тухай асуудал. Гэтэл австричууд үүнийг арилжааны өртгийн асуудал мэт эндүүрсэн байна. Өмнө, манай зохиогчоос эшлэл хийсний дагуу, таваарын солилцоо хийхэд хэн ч зах зээл дээр хөдөлмөрийн, нийгмийн дундаж зардлыг хэмжих гээд зогсч байхгүй. Гэхдээ түүхэн цаг үеийнхээ нөхцөлд, өөрийнхөө боломж буюу худалдан авах чадварын хэрээр сонголт хийгээд зогч байдаг нь маргаангүй үнэн. Энэ явцад үнийн хэлбэлзэл үүсдэг. Үүнийг урьдын сонгодогууд, өртгийг тойрон эргэлдэх үнийн хөдөлгөөн хэмээн томъёолсон юм. Тэр хөдөлгөөний цаана хэрэглэгчийн зүгээс таваарын хэрэгцээний өртөгт хандах хандлага, түүнд өгөх үнэлгээ агуулагдаж байдгийг тэд давхар хэлсэн хэрэг. Харин австричууд үнийн энэ хөдөлгөөнийг өртгийн асуудал мэт үзэж: арилжааны өртөг, хэрэгцээний өртөг, үнэт чанар, үнэ зэргийг бүгдийг нь хольж бантагнуулсан байна.

Солилцоонд оролцож байгаа зүйлс (хүний ямарваа хүчин зүтгэлийн үр бүтээл) –ийг бий болгоход оролцдоггүй, түүнд огт хамаагүй, хий үзэгдэл болох хэрэглэгчийн хүсэл таашаалаар өртгийг тодорхойлно гэдэг бол борооны дараа огторгуйд татсан солонгыг барих гэж хөөцөлдөхтэй адил юм.

Австрийн маржиналуудын хувьд онолын зангилаа асуудлыг ойлгоогүйн улмаас үүссэн мухардал нь оюун сэтгэлгээг хүчирхийлж, объектив үндэс бүхий шинжлэх ухааны дүгнэлтийг хий хоосон сэтгэмжээр дарахад хүргэжээ.

Үнэ, ашигт чанар хоёрыг өртөгтэй холилдуулж ухаараад үнэд нөлөөлж байгаа худалдан авагчийн хүсэл таашаалын субъектив нөлөөллийг өртөгт үзүүлж байгаа нөлөөлөл хэмээн сэтгэж өөртөө тавьсан урхинаас зайлж гарсан явдалд шинэ сонгодогуудын онцлог оршино. Энэ хуурамч нотолгоо удтал хадгалагдаж, улмаар эдийн засгийн олон бүрхэг асуудлыг шийдвэрлэж өгсөн мэт ойлгогдох болжээ. Тэгээд ч манай зохиогч, хэрэглэгчийн таашаал нь өртөгт нөлөөлөөд байна уу, үнэд нөлөөлөөд байна уу гэдгийг огтхон ч бодож үзэлгүйгээр бантагнуулан бичсэн нь их байна.

А.Смит: “Хэрэглээний /хэрэгцээний -Ч.Б/ өртөг ихтэй зүйлс нь олонхидоо арилжааны тун бага өртөгтэй буюу огт үгүй байх агаад, арилжааны асар их өртөгтэй зүйлийн хэрэглээний өртөг олонхи тохиолдолд тун бага буюу огт үгүй байх нь байна. Уснаас илүү хэрэгцээтэй зүйл тун ховор боловч түүгээр бараг юу ч худалдан авах буюу больж болохгүй. Гэтэл очир алмас хэрэглээний өртөг гэж бараг үгүй мөртөө түүний төлбөрт маш их хэмжээний төрөл бүрийн барааг авч болдог байх юм /2.38/ гээд, ийм “тайлбарын дараа ч гэсэн ямар нэг хэмжээнд ойлгогдохгүй зүйл үлдсэн бол учрыг нь заавал олоорой. Уг асуудал хэтэрхий хийсвэр, барьцгүй учир сайтар ухагдахгүй юм миний хичээл зүтгэлээс үл хамааран гарч болох юм даа.” /2.38/ хэмээн анхааруулсан. Үүнийг Австричууд үл ойшоон, зоргоор хандсаны улмаас учрыг нь зөв тайлаагүй байна. Тэд, уг “хэтэрхий хийсвэр, барьцгүй” асуудалд хандахдаа барьц алджээ. Тэр хийсвэр, барьцгүй зүйл нь юу вэ? А.Смит бичсэн нь: Хэдийгээр ямар ч таваарын арилжааны өртгийн бодит шалгуур нь түүнд шингэсэн хөдөлмөрийн

хэмжээ боловч, бодит байдал дээр өртгийг хөдөлмөрөөр хэзээ ч хэмждэггүй байна /2.40/ гэсэн буй. Смитийн энэ үгийг /логикийг/ яг энэ байгаагаар нь ойлгох учиртай юм биш л дээ.

Энэ бол таваарын өртгийг хөдөлмөрөөр хэмжин тодорхойлдог боловч тэрхүү хөдөлмөрийг зах зээл дээр мөнгөн дэвсгэрт шиг бариад солилцоо хийх боломж байдаггүй, бодит байдалд тийм юм байхгүй гэсэн үг. Харин, зарцуулагдсан хөдөлмөрийн хэмжээг тооцоолон мөнгөн илэрхийлэлд шилжүүлсэн нөхцөлд солилцоо бодитой, барьцтай болно. “Хөдөлмөр гэдэг нь хэдийгээр тайлбарлаж болох боловч бараа шигээ энгийн, илэрхий, барьцтай зүйл биш, хийсвэр ойлголт билээ” /2.41/ гэж Смит бичсэн тийм учиртай ажээ.

К.Менгер болон түүний хамтран зүтгэгчид, залгамжлагчид хэрэглэгчийн ханамж гэдэг ойлголтод түшиглэн арилжааны өртгийн тухай ойлголтыг цоо шинээр гаргаж ирсэнийг зонхилох эдийн засагчид зөвшөөрөн хүлээдэг (4.47) хэмээн манай зохиогч бичжээ. Одоо үед чухамхүү үүнийг л хүлээн зөвшөөрөх аргагүй. Мэтгэлцвэл зохих асуудлын зангилаа энд гарч ирж байгаа юм.

Өнөөдөр, австричуудын нээлт үеэ дуусгасан нь харагдаж байна. Тэдний судалгаа, дүгнэлтийн үеэс эхлээд өртгийн тухай сонгодог онолын томъёоллын зэрэгцээ түүнийг зах зээлийн үнийн асуудалтай холилдуулж тайлбарласан төөрөгдөл газар авах болжээ. Харсаар байтал ямарваа баялаг зөвхөн хөдөлмөрийн үр дүн гэдэг нь тодорхой болсоор байгаа нөхцөлд өртгийн үндсийг австричуудын томъёоллоор тайлбарлах боломж алга.

Эдийн засгийн сэтгэлгээ шинжлэх ухааны үндэстэй болж эхэлсэн нь нийгмийн материаллаг үйлдвэрлэлийн хөгжилтэй холбоотойгоор асуудлыг авч үзсэний үр дүн билээ. Энэ бол өрнөдийн тариаланч амьдралын хөрснөөс үүссэн Физиократ үзэл, улмаар мануфактурт суурилсан том аж үйлдвэрийн хөгжлөөр нөхцөлдсөн өртгийн онол. Эдийн засгийн сонгодог сургуулийн үүсэл ингэж тавигдсан. Эд баялгийн үйлдвэрлэл улам хөгжиж, хэрэглээний хангалт сайжирч, өнгө үзэмж, хийц маяг, чанарыг сонжих нь ихсэж тэр хэрээр үйлдвэрлэлд технологийн дэвшил хурдасч, бас эдийн засагт үйлчилгээний салбарын байр суурь нэмэгдсэний улмаас яваандаа материаллаг үйлдвэрлэлээ “Мартах” хүртэл толгой эргэсэн бололтой. Нөгөө талаар, зах зээлийн харилцааны түгээмэл хөгжлийн улмаас хүний бүтээлч үйл хөдлөлийн бүх хэлбэр үйлдвэрлэлийн утга агуулгатай, үр дүн нь таваарын шинжтэй, өртөгтэй, солилцооны замаар бусдын хүртээл болж байгаа явдал өртгийг зөвхөн хөдөлмөртэй холбон тайлбарладаг сонгодог сургуулийн томъёолол дангаар үлдэж буйн нотолгоо болно. “Ромео, Жулетта”-д тоглосон бүжигчид, тэр бүжгэн жүжгийг үзсэн үзэгчид хоёрын хооронд тэдний хөдөлмөрийн үр дүнд тулгуурласан зах зээлийн харилцаа үүсээгүй гэж үү? Үзвэрийн билетийн үнэ нь театрын зардал, бүжигчдийн хөдөлмөрийн зардлыг тооцоогүй гэж үү? Тэрхүү тооцоонд үндэслэсэн үнийг үзэгч дураараа өөрчилдөг гэж үү? Үнэ нь их гэвэл үзэхгүй л биз. Асуудал ингэж тавигдана.

Роман, тууж, яруу найраг, кино зохиол, драмын жүжиг, бүжиг, хөгжмийн зохиол, түүх, архелогийн судалгааны бүтээл туурвих, химийн урвал явуулж туршилт хийх, математикийн бодлого зохиох, уран зураг зурах, гэрэл

зургаар үйлчлэх, үс засах, оёх зүйх, наах, хатгах, хөшөө дурсгал босгох, хөгжимдөх, дуулах энэ бүхэн хөдөлмөрийн үр дүн бөгөөд хүн бүр өөр өөрийн өвөрмөц бүтээгдэхүүн (таваар)-ээр үндэсний баялгийн сан хөмрөгт хувь нэмэр оруулдаг. Эдгээр нь мөнгөөр хэмжин илэрхийлж болдог хүчин зүтгэл мөн.

Зах зээлийн харилцаа, түүний арга хэрэгсэл (механизм) бүхнийг хуу хаман эргүүлэгтээ татан оруулж байгаа өнөө үед юм бүхэн солилцоогоор дамжин хэрэглээнд хүрнэ. Энэ бүхний өртөгт хүмүүсийн сонирхол таашаал өөрчлөлт оруулж чадахгүй. Үүнээс үзхүл: Австрийн эдийн засгийн ухаан гэж байхгүй. Харин “сайн эдийн засгийн ухаан, муу эдийн засгийн ухаан гэж л бий” хэмээн алдарт М.Фридманы хэлсэн үг, түүнээс өмнө Английн эдийн засагч Л.Робинсын: “Үнэндээ сайн эдийн засгийн ухаан, муу эдийн засгийн ухаан гэсэн хоёрхон төрөл л бий” (6.548) гэсэн нь хамгийн үнэн болж таарч байна.

4. Маршалл ба манайхан

Манай зохиогч: ханамж болон үнийн тухай (өртгийн тухай биш байна шүү! Ч.Б) онолын цэгцтэй чиглэлийн эцэг нь Английн эдийн засагч А. Маршалл юм гээд “ханамжийн онолын талынхан эд баялгийн үнэт чанар буюу үнэлэмжийг хэрэглэгчийн ханамжтай холбогддог гэдэг нь өрөөсгөл талтай гэж А.Маршалл үздэг. А.Маршаллын гол гавъяа нь ханамжийн тухай онолыг үйлдвэрлэлийн зардлын байж болох доод түвшний хязгаартай хослон судалж уялдуулсанд оршино. Ханамжийн тухай ойлголтыг үйлдвэрлэлийн зардалтай хамтатган судалж, нэгтгэн дүгнэж байж л өртгийн тухай (үнийн тухай биш байна шүү! Ч.Б) асуудлыг тодруулж болно. А.Маршаллын энэхүү онол нь эдийн засагчдын өртөг, үнэ, орлогын тухай ойлголтын сэтгэлгээнд нэг л, ганцхан л тулах цэг олох гэж хэдэн зуун жил оролдож ирсэн бэрхшээлээс салгаж өгсөн юм. Энэхүү тулах цэг нь К.Марксын хувьд хөдөлмөр, зөвхөн хөдөлмөр, Австрийн шинэ сонгодогуудын хувьд ханамж л байлаа. (4.51) хэмээн дэлгэрэнгүй бичсэн байна. Биднийхээр, энэ сүүлчийнх өнөөдөр хэрэггүй болжээ. Тиймээс энэ талаархи А.Маршаллын дүгнэлт ч хэрэггүй. Өртгийн онолд ганц л тулах цэг үлдээд байгаа нь **хөдөлмөр**. Үүнийг л хүлээн зөвшөөрөхөд өртгийн онолын дахин шинэчлэлийн утга учир оршино.

Альфред Маршалл өртөг болон баялгийн тухай асуудлыг нягт холбоотой авч үзжээ. Гэхдээ, харамсалтай нь тэдгээрийг бөөн бантан болгосон байна. Тэрээр, юуны өмнө, баялгийн тухай үзэл бодлоо өмнөх үеийнхнээс үлэмж өргөн хүрээнд дэлгэн тавьж, олон янзаар ангилан бүлэглэж, нарийвчласан хэдий ч, тэдгээрийгээ хооронд хольж сүлэлдүүлэн, эх захгүй нуршин өгүүлсэн тул асуудлыг онолын хувьд үнэ цэнэтэй гэхээсээ төвөгтэй болгосон нь давамгайлж байна.

Манай зохиогчийнхоор бол Маршаллын энэ оролдлого таваарын өртгийн хэмжээнд хөдөлмөрөөс гадна өөр хүчин зүйл (хэрэглэгчийн таашаал) нөлөөлдөг хэмээн батлахыг зорьсон эрэл хайгуулынх нь туулах ёстой зам байсан болж таарч байна. Өртгийн талаархи, А.Маршаллын хоёр хэмжүүрт үзэл баримтлал нь төөрөлдлөөсөө гарсан төөрөлдсөн арга юм. Энэ нь, түүний алдарт үг хэмээгдэх болсон “хайчны ир” –ийн тухай, хэрэг дээрээ ямар ч логик

утгагүй, өртгийн хэмжүүрт үнэндээ хамаарах юм огт үгүй зүйрлэлээр илэрдэг. Тэрээр, зах зээлийн үнэ бол ахиуц ашигт чанараар тодорхойлогдох эрэлтийн түвшингээс хамаарах үнэ; ахиуц зардлаар тодорхойлогдох нийлүүлэлтийн үнийн аль альных нь үр дүн гэж үзээд үүнийгээ, цаасыг хайчилсан л бол, хайчны аль ирээр цаас зүсэгдсэн тухай маргах аргагүй хэмээн үзсэн нь ер авцалдаагүй зүйрлэл.

Уг нь өртгийн талаархи А.Маршаллын ойлголт өмнөх сонгодогуудынхтай адил билээ. Тэрээр: “Өртөг буюу аль нэг зүйлийн, тодорхой газарт, тодорхой үед, өөр зүйлийн нэгжээр илэрхийлэгдсэн арилжааны өртөг, тэр илэрхийлэгдэж байгаа зүйлийн нэгжээр сольж болох уг зүйлийн тоо хэмжээ юм” гэсэн төдийгүй, үүнийгээ тодорхой тоон үзүүлэлтээр нотлон харуулсан байна. Тухайлбал, тэрээр: “тугалга, банз, будаа зэргийн өртгийг эхлээд мөнгөн нэгжээр илэрхийлж, ийм байдлаар гаргасан зүйлийн өртгийг үнэ гэж нэрлэдэг” (2.60) хэмээн тов тодорхой бичсэн бий. Энэ санаа нь түүний томъёолсон дараах хоёр илэрхийлэлд давтан өгүүлэгдсэн байгаа.

1. “Эдийн засгийн ухаан нь нэг талаар, баялгийн тухай шинжлэх ухаан, нөгөө талаар, мөнгөөр илэрхийлэн хэмжиж болох хүчин зүтгэлд хамаарах хүний үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны нэг хэсэг” (3.52),

2. **Баялаг** гэдгийг хэрэглээний зүйл болон таашаал өгөх зүйлсийн хэлбэрээр илэрч байгаа үйлдвэрлэлийн үр дүнгийн тухай ярихад хэрэглэдэг уламжлал нэгэнт тогтжээ” (3.74) гэсэн байна. Энэ бүхэн нэг л зүйлийн тухай нэг л санаа буюу аливаа баялаг мөнгөөр илэрхийлэн хэмжиж болох бөгөөд хүний ямарваа хүчин зүтгэл (өмнө бидний дурьдсан жишээнд өгүүлсэн), хүн бүрийн өвөрмөц үйлдвэрлэл” (хөдөлмөр) –ийн үр дүн гэсэн санаа юм. Өөрөөр хэлвэл, А.Маршалл баялгийн тухай ойлголтыг өргөтгөн тайлбарлах тутмаа, хүний ямарваа хүчин зүтгэлийг мөнгөөр илэрхийлэн хэмжиж болох тухай нэмэн өгүүлэх тутмаа таваарын өртгийн нөгөө хэмжүүр нь хэрэглэгчийн сонирхол таашаал гэх хоёр дахь үзлээсээ улам бүр холдсон байна.

Асуудлын шийдэл ийнхүү нэг л цэгт төвлөрөх нь зайлшгүй юм. Өөрөөр байх боломж үгүй. Тиймээс өртгийн талаархи өмнөх сонгодогуудын онолын томъёолол дангаар үлдэж байна. Ж.С.Миллийн нотолсоноор, XIX зууны дундуур нэгэнт төгс гүйцсэн өртгийн онол дээр нэмэх юм эдүгээ алга. Харин шинэ сонгодог гэх субьектив бүрхүүлээс нь цэвэрлэх цаг хэдийнээ болжээ.

Ажиглаваас, ганц манай зохиогч ч биш, янз бүрийн орны эдийн засагчид, Маршаллын санааг өөр өөрийнхөөрөө сэлбэн тайлбарласаар иржээ. Авч үзэж буй асуудал, томъёолон буй ойлголтуудын талаар хэт нуршиж, түүндээ өөрөө орооцолддог явдал Маршаллын сул тал байсан болох нь тодорхой харагдаж байна. Тиймээс тэрээр, асуудлыг лавшруулан өгүүлэх тутмаа *өртөг, үнэ* хоёрыг холилдуулж, өөртэйгээ зөрчилдсөн нь зонхилжээ. Тэрээр, “хоёрдугаар зэргийн асуудлыг эцэс төгсгөлгүй тоочиж судалгаагаа хүндрүүлэхгүй байхыг хэм хэмжээний мэдрэмж биднээс шаардаж байна” (3.69) гэх мөртөө өөрөө түүнийгээ сахин биелүүлж огтхон ч чадаагүй ажээ. Манайхан энэ байдлыг анзаарах нь бүү хэл зүгээр л дуулианд автан хөөрцөглөсөн болох нь хэд хэдэн зүйлээр харагдана.

А.Маршаллын “Зарчмууд”-ыг жаахан тогтосхийж, анхааран уншвал өөр байдал ажиглагдана. Энэ бол тухайн үедээ гарч ирэх л ёстой байсан, цаг үеийнхээ үнэлэлт хүндэтгэлийг хүлээсэн, түүхэнд байдаг л нэг зохиол. Энэ зохиолын өнөөдөр хүртэл хадгалагдаж ирсэн үнэ цэнэтэй зүйл нь өртгийн тухай өмнөх сонгодог онолыг хүлээн зөвшөөрсөн, давтсан явдал мөн.

5. Өртгийн онолыг Шумпетер хэрхэн үзэв

XX зууны нэрт эдийн засагч, социологич, Америк, Австрийн эрдэмтэн Иозеф Шумпетерийг “Капитализм, социализм, ардчилал” /1942/ гэдэг номоор нь олон улсын хэмжээнд мэднэ. Тэрээр энэ номынхоо эхний 4 бүлгийг Карл Маркст зориулсан байдаг. Тэр; Карл Марксыг зөнч, нийгэм судлаач, эдийн засагч, багш гэж үнэлэхдээ өөртэйгээ зөрчилдсөн элдэв дүгнэлт, тайлбар хийсэн байна. Бид энд, тэр болгоныг бус зөвхөн манай авч үзэж байгаа асуудал болох өртгийн онолыг Шумпетер гуай хэрхэн үзсэн тухайд цөөн зүйл тэмдэглэхийг зорив. Тэр эрдэмтэн К.Марксын эдийн засгийн онолд товч тайлбар өгөхөөр шийдэж 7 зүйлээр саналаа илэрхийлсэн аж. Тэгэхдээ энэ тухайгаа: бидний өмнө хүчирхэг хэтийн төлөвийг одоо ч гэсэн зурж өгч байгаа “Капитал” зохиолынх нь бүтэцтэй харьцуулвал энэ товчлол олон талаар шударга бус чанартай юм /7.31/ гэж бичсэн байна. Тэрээр 7 зүйл тэмдэглэлийнхээ эхнийхийг өртгийн онолд зориулжээ. Үзвэл; Маркс өөрийн болон дараах үеийнхний онолчдын адилаар өртгийн онолыг өөрийнхөө эдийн засгийн онолын тулгын чулуу болгохыг хичээж байв. Түүний өртгийн онол нь Рикардогийнхоос ялгагдахгүй, таваар бүрийн өртөг нь уг таваарт шингэсэн хөдөлмөрт пропорциональ хамааралтай гэж Маркс, Рикардо хоёрын аль аль нь баталж байна. Тэдний аль аль нь энэ тоо хэмжээг хөдөлмөрийн цагаар хэмжиж, хөдөлмөрийн янз бүрийн шинж чанарыг нэгдмэл нэг стандартад /жишигт/ шилжүүлэх нэг л аргыг хэрэглэж байна. Тэр хоёр хоёулаа энэ аргыг хэрэглэхэд гарах үндсэн бэрхшээлүүдэд адилаар хандаж байна хэмээн бичсэн.

Шумпетер гуай К.Марксын өртгийн онолд хандан түүнийг Рикардогийнхоос ялгарахгүй гэж үзсэн боловч нарийвчласан судалгаа бүхий К.Марксын онол хавьгүй хол урагшилсаны дүнд нэмүү өртгийн онолыг бүтээсэн гэдгийг хүлээн зөвшөөрч, бас ч өндөр үнэлсэн байх юм билээ. Нэгийг нь шүүмжлэн няцааж, нөгөөг хүлээн зөвшөөрч баяжуулах зэргээр тэр ямар ч асуудлын мөн чанарт хүрч чаддаг байлаа. Үүний баталгаа бол түүний онолын санаачлагын хөшөө дурсгал болсон “нэмүү өртгийн онол” гэдэг бүтээл юм /7.29/ гэж Шумпетер бичжээ. Харин тэрээр, өртгийн энэ онол нь шаардлагад нийцэхгүй гэдгийг хүн бүхэн мэднэ гэх мөртөө, энэ сэдвээр явагддаг тоо тоомшиггүй маргааны үеэр нэг л талынх нь үргэлж зөв байна гэж байдаггүй ба хөдөлмөрийн онолыг няцаагчид ч гэсэн багагүй алдаа гаргаж байна /7.32/ хэмээн тэмдэглэсэн. Энд яг л А.Маршаллын байр суурь давтагдаж байгаа юм. Тэрчлэн Шумпетер гуай “шаардлагад нийцэхгүй” гэдгийгээ батлаагүй байна. Тэр цааш нь; төгс өрсөлдөөнөөс гадуур энэ онол хүчин төгөлдөр биш, хөдөлмөр нь үйлдвэрлэлийн цорын ганц хүчин зүйл бөгөөд бүхий л хөдөлмөр нэг төрлийн хөдөлмөр болох /зарцуулагдсан хөдөлмөр бүр эцсийн дүнд

биежсэн эд юмст хувирдаг гэсэн Марксын үндэслэлийг хэлж буй болов уу/ тэр тохиолдлыг эс тооцвол энэ онол төгс өрсөлдөөний нөхцөлд ч жигд хүчин төгөлдөр байж чадахгүй /7.32/. Түнийг халж гарч ирсэн хязгаар /ахиуц-Ч.Б/ ашгийн онол гэж нэршсэн онол эхнийхээ болон хуучирсан хэлбэрээрээ хөдөлмөрийн онолын дээр гарч чадах олон талын үндэслэлтэй. Уг онол ерөнхий шинж чанараараа давуу талтай. Энэ онол нэг талаас, монопол болон төгс өрсөлдөөний аль алинийх нь нөхцөлд адилхан хэрэглэгдэнэ. Нөгөө талаас, хөдөлмөрөөс бусад үйлдвэрлэлийн хүчин зүйлс, мөн янз бүрийн төрөл, шинж чанартай хөдөлмөр байгаа тохиолдлуудыг хамардаг гэжээ. Чухамхүү энэ л өнөөдөр утгагүй болсон гэдгийг дээр бид нотолсон. Өөрөөр хэлбэл; Шумпетерийн тэмдэглэсэн сүүлчийн 2 багц өгүүлбэрээр илэрхийлэгдэж байгаа санаанд өртгийн тухай хөдөлмөрийн онол бүрнээ нийцэх буюу бүр эсрэгээр, “хязгаар ашгийн” гэх онол л юунд ч хэрэггүй болсон байна. Тодруулбал, ХХ зуун эхлэх зааг дээр тэргүүлж байсан Австрийн эдийн засгийн сургуулийн гол зүйл болох “үнэлэмжийн онол” гэгч ХХI зуун эхлэх зааг дээр үеэ дуусгасан нь тодорхой болж байна.

Авч үзэж байгаа асуудлаар Шумпетер гуай эцэст нь юу гэснийг үзье. Өөрсдийг нь сөрөн гарч ирсэн хязгаар ашгийн онолд марксистууд эхэндээ эргэлзэж байсан нь ямар ч утгагүй бөгөөд өртгийг тайлбарлах хөдөлмөрийн онолыг ч “буруу” онол гэж нэрлэх явдал зохистой биш гэдэг нь эндээс тодорхой байна /7.33/ хэмээн бас эргэж буцжээ. Тэгсэн атлаа: “Ямар ч гэсэн тэр онол мөхөж булшлагдсан” хэмээн сүртэй зарласан байна. Харин бид, өмнөх нотолгооныхоо дагуу асуудалд бүр эсрэгээр хандаж: Өртөг хүслээр бус хөдөлмөрөөр бүтээгддэг болохыг эргэн ухаарах цаг болжээ хэмээн давтан хэлж байна.

6. Марк Скаузэний байр суурь

Профессор М.Скаузэний “Эдийн засгийн ухаан эдүгээчлэгдсэн замнал” /УБ.2003/ номыг үзхүл, манай орчуулагч: “Labour theory of Value” гэдгийг “Хөдөлмөрийн үнэлэмжийн онол” /113 дахь тал/ гээд Value гэсэн үг нь ерөөс өртгийн тухай хэлээгүй, харин үнэ цэнэ, үнэлэмжийн тухай өгүүлж байгаа юм гэхийн сацуу, тэр томъёоллыг цаашид энэ байдлаар орчуулан хэрэглэхийг санал болгож буйгаа өөрийн тайлбар зүүлтэд тэмдэглэжээ. Гэвч энэ санал тийм чухал зүйл бишээ. Учир нь юу вэ? гэвэл, Скаузэний томъёололд хамгийн гол нь хөдөлмөрийг үнэлж буй явдал чухал учраас уг орчуулгатай маргах шаардлага байхгүй.

Эдийн засагчид /хуучин, шинэ сонгодогууд/ “өртөг”, “үнэлэмж” гэсэн хоёр үгийн талаар мэтгэлцэж байгаа юм огт биш. Харин, “хөдөлмөр”-ийг тооцох, эс тооцоход /үнэлэхэд/ л санал зөрдөг юм. Хуучин сонгодогууд

болохоор, таваарыг худалдан авагчийн үнэлэмжинд, ухамсарласан, эс ухамсарласан алин боловч үйлдвэрлэгчийн хөдөлмөр заавал хамаарагдана гэдгийг; шинэ сонгодогууд хөдөлмөрийг огт хамаагүй мэт орхиж, ердөө хэрэглэгчийн хүсэл таашаал буюу тэрхүү үнэлэмжийн өөрийг нь дангаар өргөмжилдөг /А.Маршаллаас өмнө ба хойно/ явдалд маргааны уг чанар оршино.

Профессор М.Скаузэн нэгэнт хөдөлмөрийг үнэлж байгаа л бол түүний томъёололыг: “Өртгийн хөдөлмөрийн онол” гэнэ үү “Хөдөлмөрийн үнэлэмжийн онол” гэнэ үү ямар ч ялгаагүй бөгөөд зохиогчид талархал илэрхийлэхээс аргагүй. Манай орчуулагчийн тайлбар ч илүүц болно.

Очир алмас өндөр үнэлэгддэг нь хөдөлмөрийн үр дүн гэж бид хэлэх гээгүй. Тийм юм ерөөс байхгүй. Байгалийн гаралтай тэр гоёлын зүйл ердөө өчүүхэн цөөнхийн тансаг хэрэглээний зүйл болдогт л хамаг учир оршино. Харин ч түүнд илүү их хөдөлмөр зарцуулж үйлдвэрийн аргаар их хэмжээгээр үйлдвэрлэн нийтээр хэрэглэдэг болвол үлэмж хямдхан зүйл болж хувирна гэдгийг аль ч үеийн эдийн засагчид нотолдог билээ. Харин өнөө үед дэлхий дахины ундны ус улам үнэд орж байгаа нь түүний ховордолтой холбоотой, тэр хэрээр улам нарийн ухаан, чимхлүүр хөдөлмөр, хичээл, зүтгэл шаардах нь лавтай. Ийнхүү хэрэглээний нийт хэмжээ, бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор ямарваа бүтээгдэхүүний үнэлэмжийн өөрчлөлт хөдөлмөртэй холбогдохгүй нь огт үгүй.

Марк Скаузэн, “Үнэлэмж нь хөдөлмөр, эсвэл үйлдвэрлэлийн өртгөөр тодорхойлогдоно гэсэн рикардист номлол цаашид оршин тогтнохоо больжээ” хэмээн “нотлохдоо” : нэгэнт зарцуулагдсан хөдөлмөр /эсвэл капитал/ тухайн юмны цаашдын үнэлэмжид ямар ч нөлөө үзүүлж чадахгүй; өнгөрсөн юм өнгөрснөөрөө л үлдэнэ” /6.247/ хэмээн Жэвонсын үгийг эш татжээ.

Тийм л дээ. Үнэлэмж гэдэг нь зүгээр л хүсэл, санаа шүү дээ! Энэ бол өртөг биш. Үнэлэмж гээд байгаа тэр хүсэл сонирхолыг хөдөлмөрөөр тодорхойлно гэсэн зүйл сонгодогууд хэлээгүй. Бидний онцлон яриад байгаа зүйлийн гол утга учир энд л байгаа юм. Австрийн субъектив маржинализм, түүнд тулгуурласан английн маржиналууд өртөг, үнэ хоёрыг хольж бантагнуулсныг бид өмнө дурдсан.

Нэгэнт зарцуулагдсан /өнгөрсөн буюу биежсэн/ хөдөлмөр тэр хэвээрээ л байна. Өртгийн хэмжээг заана. Үнэд нөлөөлөхгүй, “өнгөрсөн юм өнгөрснөөрөө л байна”. Харин уг юм /таваар/ ямар үнээр худалдагдах нь тухайн хэрэглэгчийн хүсэл сонирхол, таашаал, өөрөөр хэлвэл, тэдний үнэлэмжээс шалтгаалах нь яах аргагүй үнэн. Асуудлыг ингэж ойлговол австричуудын гаргаж ирсэн хэрэглэгчийн **үнэлэмж**, сонгодогуудын томъёолол болох **өртөг** хоёрын хооронд ямар ч хамаарал байхгүй.

Тэрхүү үнэлэмж нь үнийн төвшинд л нөлөөлнө. Хэрэглэгч /худалдан авагч/-ийн хүсэл таашаалаас огт хамаарахгүйгээр бараа, үйлчилгээнд шингэсэн, үйлдвэрлэгчийн хөдөлмөр л өртгийн үндэс мөн. Тэр нь эцсийн дүнд үйлдвэрлэгчийн нийт зардлыг тусгах бөгөөд нийлүүлэгч түүнийгээ /зардлаа/ хэрхэн нөхөх, ашиг олох эсэх нь хэрэглэгчийн таашаалыг хэр зэрэг харгалзаж

чадахаас хамаарна. Энэ бол зах зээлийн үнийн тухай асуудал. Харин тэр таашаал үйлдвэрлэгчийн зардалд огт хамаагүй, түүнийг хэмжихгүй. Энэ утгаар, үйлдвэрлэлийн зорилго бол илүү дээр /сайн Ч.Б./, илүү хямд бараа таваар, ажил үйлчилгээг бий болгох замаар хүмүүсийн хэрэгцээг хангах явдал мөн гэж Менгер тэмдэглэсэн /6.223/ нь зөв болно.

Профессор М.Скаузэн цааш нь бичихдээ: “Өртөг нь бодит, үнэмлэхүй зүйл бөгөөд хэрэглэгчийн таашаалаас ангид /бид үүнийг л хэлээд байгаа- Ч.Б./, бие даасан ойлголт гэж Маршалл ба түүний үзлийг тайлбарлагчид үзэж байжээ. Үүгээрээ Маршалл үнэлэмж нь эцэстээ таашаалаар буюу эрэлтээр тодорхойлогдоно, өртөг нь үнэндээ алдагдсан боломжоос өөр юу ч биш гэж үздэг байсан австричуудаас ялгагдаж байлаа. Тэрээр таашаал биш, харин өртөг нь үнэлэмжийг тодорхойлох болно гэж үзсэнээрээ (энд М.Скаузэн бас буруу тийш эргэж байна - Ч.Б.) ахиуц таашаалын шинжилгээг рикардист үзэлтэй холбохыг оролдсон билээ. Өөрөөр хэлбэл, тэрээр, рикардист эдийн засаг, үнэлэмжийн онолыг аврахыг оролдсон юм” /6.258/ гэсэн байна.

Маршалл, “Хөдөлмөрийн онолыг аврахыг оролдсон” нь маш зөв бөгөөд энэ утгаар түүний онол яваандаа маржинал субъективизмээс бодит байдалд үндэслэсэн онол буюу өртгийг хөдөлмөрөөр тодорхойлдог сонгодог онолд буцаж ороход чиглэсэн “эргэх шилжилтийн онол”-ыг бүтээсэн гавъяатай юм.

Чухам энэ утгаар, “Менгер болон австрийн бусад эрдэмтэд Рикардогийн эдийн засгийн обьектив механик детерменизмийг хүний үйл ажиллагаа болон үнэлэмжийг тооцсон харьцангуй субъективизмээр сольжээ” /6.213/ гэсэн М.Скаузэний дүгнэлт хэрэггүй болж байгаа юм.

Үйлдвэрлэгчид бол хөгжлийн хувь заяаг шийдвэрлэгчид, ямагт хүнд ачааг нь үүрэгчид байдаг. Харин хэрэглэгчид бол хэрэглэгч л байдаг. Хэрэглээний өсөлт, соёлжилт нь үйлдвэрлэлийн хөгжил, шинэчлэлд шинэ санаа, түлхэц өгдөг ч гэлээ зүтгүүр болдоггүй. Тиймээс хэрэглэнэ гэдэг бол аливаа баялгийг эдлэх, ашиглахад бэлэн болгосны хойно нь тухайлбал, үйлдвэрлэсний дараа авч хэрэглэдэг гэсэн үг. Тэгэхээр хэрэглэгч бол бэлэн болгосныг шилж сонгож, элдэвтэй аашлан байж аль болох хямд авчихыг л оролддог “хар бирд” мөн. Тэдний хувьд, үйлдвэрлэгчид яаж хичээн зүтгэж, ямар зардал гаргаж /ямар өртөг бүтээж/, ямар тооцоотой ажилласан нь огт падгүй. Тийм учраас “Аугаа их үйлдвэрлэгчдийн” /Айн Рэнд/, “Хуримтлагдсан хөдөлмөр”-ийн /Д.Рикардо/ нийт зардлаас бүрддэг өртгийг тодорхойлоход тэдний (хэрэглэгчдийн) хүсэл сонирхол огт хамаагүй. “Таваарын өртөг”, “хэрэглэгчийн үнэлэмж” гэдэг тэс ондоо хоёр зүйлийг ялгаж чадаагүйгээс үүдсэн төөрөгдлийг зөвтгөх ямар ч үндэс алга.

Марк Скаузэн номондоо: Өртгийн онолд хамаарагдахгүй байгаа, “Ховор бөгөөд онцгой чанартай хөшөө баримал, зураг, ном, мөнгө, дарс” мөн машин тоног төхөөрөмжийн үр ашгийн талаар тэр /Рикардо/ ухамсарлаж байсан. Гэхдээ машин тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгө нь ердөө л хуримтлагдсан хөдөлмөр гэж үзэж байжээ /6.131/ гэснийг яг эсрэгээр нь эргүүлэн тавьж Рикардогийнх зөв гэж үзэх учиртай.

X

X

X

Лавлагаа: К.Марксын “Капитал” зохиолын I ботийн тайлбар зүүлтэд дараах тайлбарууд өгүүлэгдсэн байна.

1. “XVII зууны үед Английн зохиогчид хэрэглээний өртгийг Worth гэсэн үгээр, арилжааны өртгийг Value гэсэн үгээр тэмдэглэж байсныг бид олон удаа үзнэ. Энэ нь биеэрээ байж байгаа эдийг герман гаралтай үгээр; сэтгэхүйд тусгагдсан эдийг роман гаралтай үгээр илэрхийлэх дуртай англи хэлний шинжид яг таарсан ажээ” /Герман хэлнээс монголчилсон I ботийн 45 дахь тал/ Харин манайхан энэ хоёр үгийг англи хэлнээс яг нэг ижил болгон орчуулжээ. Тухайлбал, Л.Дамбадоржийн Англи, Орос, Монгол толь /УБ. 2004/ Э.Чинбатын 130.000 үгтэй Англи, Монгол толь, Ц.Мөнх-Оргилын Англи, Монгол товч толь /УБ. 2008/ зэргээс үүнийг лавлан үзэж болно.

2. Англи хэл хөдөлмөрийн хоёр ондоо талыг тэмдэглэх хоёр ондоо үгтэйгээрээ давуутай юм. Хэрэглээний өртөг бий болгодог, чанарын талаар тодорхой хөдөлмөрийг Labour гэхгүй Work гэж нэрлэдэг; өртөг бий болгодог зөвхөн тооны талаар хэмжигддэг хөдөлмөрийг Work гэхгүй Labour гэж нэрлэдэг юм. /мөн боть 58 дахь тал/

Түүнчлэн, “Если отвлечься от потребительной стоимости товарных тел, то у них остается лишь одно свойство, а именно то, что они-продукты труда” /Капитал” том первый. М.1973.стр.46/ гэснийг өнөөдөр юугаар няцаах юм бэ?! Шинжлэх ухааны хийсвэрлэлийн аргаар аливаа хэрэгцээний өртгөөс, таваарын биеийг авчихвал цаана нь ердөө л хөдөлмөрийн бүтээгдэхүүн үлдэх нь үнэн шүү дээ. Ингэхээр, “үнэлэмжийн бүтээгдэхүүн” гэж юу байх юм бэ? Хаана ч тийм юм алга. Байх ч үндэсгүй.

Дүгнэлт

Өртгийн онолыг дахин шинэчлэх сэтгэлгээний явцаас гарах эцсийн дүгнэлт бол: Маржинал хувьсгалын үр дүн өдгөө нэгэнт хэрэггүй болсон; Энэ хувьсгал анхандаа, өртөг, үнэ хоёрыг ялгаж ойлгоогүй төөрөгдлийн уршиг болон үүссэн; Ингэхдээ тулгуур болгосон ойлголт нь:

1. Үйлдвэрлэлийн хөгжилтэй уялдсан баялгийн хуримтлал, хэрэглээний соёлын өсөлт нь хүмүүн заяатны тансаглах, сонжих ааш араншинг дэвэргэж, шилж сонгож хэрэглэх хүслийг өдөөсөн. Тэр нь улмаар дархлагдсан эрх болж зах зээлийн үнэд нөлөөлөх болсон. Өөрөөр хэлбэл, хэрэглэгч нь нийлүүлэгчийн зардал буюу өртгийн мөнгөн дүнг заавал хүлээн авахгүй, зөвхөн өөрт таалагдсан зүйлд үнэ төлөх (өртөг биш шүү!) түүхэн шинэ нөхцөл бүрдсэнийг ташаа ухаарсан;

2. Өртөг бол зөвхөн хөдөлмөрийн үр дүн гэдгийг хөдлөхийн аргагүйгээр яг таг нотолсон сонгодог сургуулийн хэрэгсээгүй зүйл буюу баялгийн олодоц (элбэг ба ховор байдал) нь өртөг бүтээхэд ямар ч хамааралгүй, гагцхүү зах зээлийн үнийн түвшинд хийсвэрээр нөлөөлдөг, хөдөлмөрийн бус хүчин зүйл болохын хувьд нь асуудлын гадна орхисоныг шүүрэн авч өртгийн нэг үндэс мэтээр ташаа ухаарсан явдал болно.

Өртгийн онол бол зах зээлийн эдийн засгийн ухааны тулгын чулуу, хамгийн ээдрээтэй хэсэг, үлэмж нарийн төвөгтэй асуудал. Тиймээс ч энэ асуудлыг тойрсон маргаан мэтгэлцээн зуун дөчөөд жил үргэлжлээд хэсэг намжсан боловч өдгөө бидний оюуныг дахин зовоож эхэллээ. Мөшгин үзхүл, уг онолыг дахин шинэчлэхээс өөр аргагүй болжээ. Энэ бол хэрэг дээрээ түүнд нэгэн янзын мэс засал хийнэ гэсэн үг. Энэ бол А.Маршалл зохиомлоор хоёр суурьтай болгочихсон өртгийн онолоос австрийн сургуулийн субъектив, гажуу дүгнэлтийг авч хаяна гэсэн үг.

Австрийн сургууль гэдэг бол XIX зууны 70-аад оны эхээр эдийн засгийн онолын сэтгэлгээнд орж ирсэн, тухайн үедээ их шуугиан тарьсан, өдгөө ч үнэ цэнэтэй гэж тооцогдсоор байгаа субъективизм шүү дээ! Өнөөдөр энэ нь өртгийн онол дотор бугласан “Мухар олгой” болоод байна. Үүнийг авч хаясанаар өртөг бол хөдөлмөр гэдэг ганц л үндэстэй болох тухай сонгодог томъёолол цэвэршин үлдэх болно. Зах зээлийн харилцааны өнөөгийн бодит байдлыг үзвэл, хүмүүний хэрэгцээт аливаа баялаг зөвхөн хөдөлмөрийн ачаар л хэрэглэгдэх боломжтой болдгийг ойлгоход тийм ч хүнд биш ээ. Ийнхүү эдийн засгийн ухаанд өртгийн онол эргэн ирж байна.

Ашигласан ном зүй

1. Антология экономической классики:
В.Петти, А.Смит, Д.Рикардо. М.1993, с.54.
W.Petty. “A Treatise of Taxes and Contrisbutions”. London 1667. p.47
2. А.Смит. Үндэстнүүдийн баялаг. УБ.1998
3. А.Маршалл. Эдийн засгийн ухааны зарчмууд.
Чойбалсан хот. 1997
4. П.Жасрай. Эдийн засгийн онол. УБ.2002
5. Л.Мизэс. Либерализм. УБ.2004
6. М.Скаузэн. Эдийн засгийн ухаан эдүгээчлэгдсэн замнал. УБ.2003
7. И.Шумпетер. Капитализм, Социализм, ардчилал. УБ.2006